



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2018.03.25 № 06/111
танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

136
Г
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ж.ЭНХТӨР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.3-д заасны дагуу Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт,

түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар

Аудитын код: ХЭА-2018/3/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Хаяг: Khentii@audit.gov.mn

Бүрэгүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар

Тас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Тас: 99775390

Халах аудитор: Н.Туяа

Тас: 99799709

АГУУЛГА

Аудитын тайлан	2
1.1 Оршил	2
1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	3
1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	4
1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
1.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	5
1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	6
1.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	7
1.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	7
1.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
1.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
1.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
1.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
1.12 Шилэн дансны мэдээлэл	8
1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
1.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9

1. АУДИТЫН ТАЙЛАН

1.1 Оршил

Дархан сумын Төсвийн Ерөнхийлөн захирагч Ж.Энхтөр- д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод саналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, өргөсөн шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус тураангуйлан тэмдэглэв.

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 6 төсвийн байгууллага, 4 орон нутгийн тусгай сан, сумын төрийн сан 1, орон нутгийн өмчид үйлдвэрийн газар 1 зэрэг нийт 12 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Дархан сумын ЗДТГ, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд хувийн аудитын "Ай Жей Эй Эйч аудит" компани аудит хийж "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргасан байна.

Сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын хүрээнд сумын ИТХ, Соёлын төв, Эмийн эргэлтийн сан зэрэг байгууллагууд болон Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгаж дүгнэлт гаргав.

Аудитаар:

1. Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд хийсэн аудитаар алдаа зөрчил илрээгүй тул зөрчилгүй дүгнэлт өгсөн.
2. Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 2.7 сая төгрөгийн, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 0.2 сая төгрөгийн, нийт 2.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2.7 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийн, 0.2 сая төгрөгийн зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж өгч, зөрчилгүй дүгнэлт өгсөн.
3. Ерөнхий боловсролын цогцолбор сургуулийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой 1.2 сая төгрөгийн, бүртгэл тайлагналтай холбоотой 7.5 сая төгрөгийн, нийт 8.7 сая төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрснээс 7.5 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийн, зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлж, зөрчилгүй дүгнэлт өгсөн.
4. Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 0.7 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрсэнд 5 зөвлөмж хүргүүлж, зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.3 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Дархан сумын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.02.25-наас 2017.03.25-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.03.24 - нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Туяа хариуцаж хэрэгжүүлэв.

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017.03.05 - нд, 2017.03.03-ны өдрийн 1/108 дугаар албан бичгээр аудит хийлгэх хүсэлтээ төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд аудитын олон улсын стандарт, санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Дархан сумын санхүү төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж гүйцэтгэлийг хангах нөөцийг оновчтой ашиглаж хариуцлагын тогтолцоог уялдуулах, төрийн сангийн шуурхай үйлчилгээг бий болгож төсөв санхүүгийн таатай орчин бүрдүүлэх замаар, санхүү эдийн засгийн үр ашигтай удирдлагаар хангахад оршино” гэж тодорхойлсон эрхэм зорилгын дор сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэхдээ "Э-тайлан" нэгтгэлийн програмаар гаргажээ.

1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.2 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 5 асуудал эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 15 буюу дунд эрсдэлтэй байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 5 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Нийт орлогоос тооцоход улсын төсөвт төвлөрүүлдэг буюу байгууллагын үйл ажиллагаанд зарцуулдаггүй орлого нэмэгдэж тооцогдоно, нийт хөрөнгө болон цэвэр өмчийн дүн өндөр байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1744.8 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 17.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

Материаллаг байдлын түвшин болон нөхцөл байдал, шинж чанарын хувьд материаллаг байдал илрээгүй.

1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 4 чиглэлээр 5 эрсдэлтэй асуудалд 5 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд алдаа зөрчил илрээгүй болно. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 аялгаар нэгтгэж, баримтжуулав.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дахь залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	4	7.6	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	4	7.6	

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлөвлөгөөний дагуу горим сорил гүйцэтгэхэд төрийн сангийн нэгтгэлд алдаа зөрчил илрээгүй болно.

Нэгтгэсэн тайлангийн хүрээнд байгууллага, сангуудыг аудитын түүвэрт хамруулан шалгахад илэрсэн асуудлыг танилцуулвал:

1. Сумын ИТХ-ын санхүүгийн тайланд хийсэн түүврийн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд 24 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрсэнд 1 зөвлөмж хүргүүлсэн.
2. Соёлын төвийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгахад Шилэн дансны цахим хуудсанд 26 мэдээллийг хугацаа хоцроосон, 5 сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээнд 5.7 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй зөрчил илэрсэнд 1 зөвлөмж хүргүүлсэн.
3. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгахад зардлыг батлагдсан төсөл арга хэмжээгээр ангилан бүртгээгүй,

ямар төсөл арга хэмжээнд зарцуулсан нь тодорхойгүй шатахууны үнэ 1.9 сая төгрөгийг төлж, урсгал зардалд зарцуулсан байна.

4. Эмийн эргэлтийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгахад нягтлан бодох бүртгэлийн журнал, дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөөгүй, санхүүгийн тайланд үйл ажиллагааны үр дүнг үнэн зөв илэрхийлээгүй байна.
5. Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгахад зөрчил илрээгүй.

1.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлөвлөгөөний дагуу горим сорил гүйцэтгэхэд төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй болно.

1.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлөвлөгөөний дагуу горим сорил гүйцэтгэхэд албан шаардлага үргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

1.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлөвлөгөөний дагуу горим сорил гүйцэтгэхэд сахилгын шийтгэл ногдуулах алдаа зөрчил илрээгүй болно.

1.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлөвлөгөөний дагуу горим сорил гүйцэтгэхэд хууль хяналтын байгууллагад шилжүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

1.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй.

1.11 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан гэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Сумын төсвийн орлогын төлөвлөгөөг 30.5 сая төгрөгөөр батласнаас гүйцэтгэлээр 71.5 сая төгрөгийн орлого төвлөрч, орлогын төлөвлөгөө 234.4 хувиар уюу 41.0 сая төгрөгөөр давж биелсэн байна. Үүнд: Үйл ажиллагааны орлого 22.0 сая төгрөгөөр, нэр заагдаагүй бусад орлого 11.6 сая төгрөгөөр, торгуулийн орлого 3.6 сая төгрөгөөр, хог хаягдлын орлого 3.4 сая төгрөгөөр давж биелсэн нь нөлөөлсөн байна.

Үйл ажиллагааны орлогод шинээр хадгаламжийн хүүгийн орлого, торгуулийн орлогод цагдаагийн торгуулийн орлогыг, нэр заагдаагүй бусад орлогод газрын худалдаа худалдааны орлогын 30 хувийг орон нутагт төвлөрүүлсэнтэй холбоотойгоор орлого давж биелсэн байна.

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 1099.2 сая төгрөгийн, хөрөнгийн зардалд 132.3 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/ сая төгрөгөөр/

	үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь	зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,276.9	1,224.3	95.9	52.6
1.1	Урсгал зардал	1,099.2	1,070.4	97.4	28.8
1.2	Хөрөнгийн зардал	132.3	110.9	83.8	21.4
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	45.4	43.0	94.7	2.4
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,276.9	1,146.5	89.8	(130.4)
2.1	Улсын төсвөөс санхүүжих	769.6	765.0	99.4	(4.6)
2.2	Орон нутгийн төсвөөс санхүүжих	340.1	338.0	99.4	(2.1)
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	161.5	12.9	8.0	(148.6)
2.4	Бусад эх үүсвэрээс	5.7	30.6	536.8	24.9

Төсөвт зардлын гүйцэтгэл 52.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь улс болон орон нутгийн төсвийн урсгал зардал 28.8 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 21.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн болон 2.4 сая төгрөгийн эргэж төлөгдөх зээлийг олгоогүйтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын биелэлт 8 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь урьд оны үлдэгдлээс санхүүжих орлого 149.3 сая төгрөгөөр дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

1.12 Шилэн дансны мэдээлэл

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг зөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлсэн байна.

1.13 Өмнөх зөвлөмжийн ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

1.14 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дархан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ий өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн зөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил үйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, гударга илэрхийлсэн байна гэж үзэж "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийг энэ тайлангийн 1.8-д нэгтгэн тусгасан бөгөөд илэрсэн алдаа зөрчил нь бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс бага тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлт, аудитлагдсан санхүүгийн тайлан 9 хуудсыг тус тус авсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ



ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР Огноо:

Д.ОЮУНТУЯА Огноо: 2018.3.24

Н.ТУЯА Огноо: 2018.03.22

БЭЛТГЭСЭН: